

МОНГОЛЫН АНДРЮС

Р.Болд

Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

Өггүүлийн товч утга: Энэхүү өгүүлэлд Монголын Андрюс хэмээн алдаршсан нэгэн судлаачийн Монгол судлалд оруулсан хувь нэмрийн тухай өгүүлэх болно. Тэрбээр Америкийн Байгалийн түүхийн музейгээс Монголд зохион байгуулсан Төв Азийн гурван удаагийн экспедицийг ахлан ажиллаж, "Монголын талыг гаталсан нь", "Эртний хүний мөрөөр", "Төв Азийг шинээр байлдан дагуулсан нь" хэмээх бүтээлүүд болох олон өгүүлэл нийтлүүлж, тэр үеийн байдлыг тольдон харуулсан олон арван гэрэл зураг татаж үлдээжээ.

Түлхүүр үг: Археологи, хайгуул, судалгаа, Төв Ази, экспедици, үлэг гүрвэлийн яс, өндөг, буриад

Судлаач А.Дамдинсүрэн Р.Андрюсийн толгойлсон экспедицийн Монголд хийсэн судалгааны тайланг нарийвчлан судлахын чухлыг 1991 онд дэвшүүлэн тавьж байсан билээ.¹ Р.Андрюс 1884 онд Висконсин мужид төрж, сургууль төгссөний дараа Нью Йорк хотод Америкийн байгалийн түүхийн музейд өөрийнхөө хүслээр 1906 онд ажилд оржээ. Музейн судлаачийн хувьд Солонгос, Япон, Орост угсаатны түүх судлах зорилгоор аялж байжээ. Харин Г.Обсон Нью Йорк хотын Байгалийн түүхийн музейн ерөнхийлөгчөөр 1908 онд сонгогдож ажиллах болсоны дараа тэд Төв Азид судалгаа хийх талаар санаа нэгдсэн байна. Америкийн эрдэмтэд, байгалийн түүхийн суурь судалгааг үндэслэн Монгол орон бол эрт галавын амьтад болон хүний гарал үүслийн өлгий нутаг мөн гэсэн таамаглал дэвшүүлсэн онолын магадлагааг нотлох зорилгоор Төв Азид шинжилгээний анги илгээх бодолтой байжээ.² Р.Андрюс дээрх бодлыг хэрэгжүүлэхийн тулд туршлага хуримтлуулах, зарим мэдээллийг нотлох зорилгоор зүүн өмнөд Ази, Хятадын зарим хэсгээр аялж археологийн хайгуул, судалгаа хийж байв. Америкийн тэнгисийн цэргийн тагнуулын алба Р.Андрюст хандан нууц ажилтнаар элсүүлж, Хятадын тухай мэдээлэл цуглуулах зорилгоор Хятадад очихыг санал болгосоныг тэрээр хүлээн авчээ. Тэрээр зоологийн судалгааны халхавчаар Хятадад ажиллахдаа алс дорнодын улс төр, цэргийн байдлын талаар мэдээлэл цуглуулж Америкийн засгийн газарт өгөх үүрэгтэй байжээ. Андрюсын амьдрал, үйл

¹ А.Дамдинсүрэн. "Монгол-Америкийн харилцааны эхлэл". Дорно Өрнө №3. УБ., 1991. 57-62 дахь тал

² Ц.Пунцагноров. "Монгол-Америкийн харилцааны туулсан зам, хамтын ажиллагааны өнөөгийн төлөв". Дорно Өрнө №1. 1994. 42 дахь тал

ажиллагааг судалсан Ч.Галленкэмп “Андрюс нь Дорнод Азид Америкийн бодлогыг боловсруулахад хэрэгтэй төрөл бүрийн сэдвээр мэдээлэл цуглуулах үүрэгтэй байсан янз бүрийн далбаан дор ажиллаж байсан олон тооны иргэний мэдээлэгч нарын нэг байсан гэдгийг нууцлалыг ил болгосон саяхны баримтууд нотлов...Монголд аялахдаа Андрюсийн ажиглалт нь дотоод байдал, цэргийн чадавхи, большевик хувьсгалын болзошгүй нөлөө, Монголын улс төрийн төлөвт гүнзгий нөлөөлж болох үйл явдал, Оросын дотоод байдал зэрэгт төвлөрч байжээ. Монгол дахь аялалын далд зорилгоос гадна эдгээр аялал нь Төв Азийн энэхүү хэсэгт шинжлэх ухааны ирээдүйн судалгааг үнэлэх боломж олгожээ” гэж бичсэн байна.³ Америкийн байгалийн түүхийн музейн судлаач Андрюс 1918 оны IX сард анх Өргөөд иржээ. Энэ тухайгаа Нью Йорк хотод хэвлэгддэг “Harper's Magazine” сэтгүүлийн 1919 оны VII сарын дугаарт “Моторт машинаар Монголыг гаталсан нь” өгүүлэл нийтлүүлжээ. Энэхүү өгүүлэлтэй хамт Гандан хийдийн гэрэл зураг анх нийтлэгдсэн нь хожим өрнөдийн хэвлэлд өргөн ашиглах болжээ. Андрюс бичихдээ Өргөө хэдэн долоо хоногийн туршид дайн гарч болзошгүй уур амьсгалтай байв. Сибирийн Байгал нуурын бүсэд хэдэн мянган мажар, олон тооны большевикууд байв. Чехүүд тэднийг довтлох нь тодорхой байсан бөгөөд хэрэв ялагдвал хил даван Монголд орж ирэх байв. Энэ тохиолдолд Монголын засгийн газрын байр суурь ямар байх бол? Тэд дайсагнагч хүчийг саатуулах, эсвэл Өргөөг түшиц газар болгон ашиглуулах болов уу? Монголын цэргийн, Гадаад яамны сайд Цэрэндорж Гуптилд хэлэхдээ: Монголд ирсэн Орос, Мажарууд зохистой байвал саад болохгүйгээр үлдэхийг зөвшөөрнө, хэрэв самуун үүсгэвэл саатуулна хорино гэсэн байна. Өргөөд 10 мянган хятад, 2 мянган орос, 50 мянган монгол, тэдгээрээс 35 мянга нь лам нар амьдардаг байна гэж бичжээ.⁴ Энэхүү сэтгүүлийг Андрюс Тэрэлжид байхдаа авсан гэж бичсэнээс үзэхэд шуудан харилцаа Хаалган-Өргөөгийн хооронд сайн байсныг харуулна. Андрюс хоёр дахь удаагаа Монголд 1919 оны 5 дугаар сарын дундаас 9 дүгээр сарыг дуустал байхдаа Тэрэлжид сар гаруй байж, нутгийн нэгэн сайн анчинг дагаж ан хийж байжээ. Андрюс Оросын консул А.Орловтой уулзаж, Өргөө хавьд ажиллах зөвшөөрлийг Монголын засгийн

³ Charles Gallenkamp. “Dragon Hunter”. Penguin Book . УБ.,2001. p.72-73

⁴ Roy Andrews. “Across Mongolia by Motor-Car”. Harper's Magazine. July 1919. p.14

газраас түүний туслалцаатайгаар авсан байна. Орлов түүнийг Өргөөд ирээд байсан Сайн ноён хан Намнансүрэнгийн бэлбэсэн хатантай танилцуулж байжээ. Гэргийн байдал сурвалжит шинжтэй, дагалдсан бараа бологсод, унасан морь зэргээс үүдэн маш баян хатан байв гэж Андриос бичжээ.

Андриос Монголд очсон хоёр удаагийн аялалынхаа тэмдэглэлд үндэслэн “Монголын талыг гаталсан нь” хэмээх ном 1921 онд хэвлүүлсэн нь олны анхаарлыг ихэд татжээ. Гэхдээ энэ нь түүний төлөвлөсөн Төв Азид археологийн томоохон экспедици зохион байгуулахын тулд ивээн тэтгэгч, сонирхогчдын анхаарлыг татах гэсэн зорилготой байв. Учир нь Төв Азийн экспедицийг зохион байгуулахад үлэмжхэн хөрөнгө хэрэгтэй байв. Р.Андриос Америкийн “Harper's Magazine” сэтгүүлийн 1919, 1920 оны дугааруудад Монголын тухай гурван томоохон өгүүлэл, Америкийн дорно дахины судлалын “Азийн сэтгүүл”-ийн 1921-1924 оны дугааруудад Монголд аялсан тухайгаа өгүүлсэн арав гаруй өгүүлэл, олон тооны гэрэл зургийн хамт тус тус нийтлүүлжээ. Эдгээр материал нь түүнд “Монголын Андриос” гэдэг нэр өгүүлжээ. Р.Андриосын тэмдэглэлд Монголын тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал, Монголын төрийн зүтгэлтнүүд, Монголд ажиллаж байсан Америк худалдаачдын тухай өргөн мэдээлэл тусгагджээ. Америкийн худалдаачин Голтман, Мамен нар машинаар говийг гатлан Өргөөд 1916 онд очиход Богд гэгээн машиныг нь сонирхон худалдан авсаныг Андриос ярьж байжээ. Р.Андриос Богдын ордон дотор автомашины арвин цуглуулга байхыг 1919 оны зун хараад дуу алдаж байжээ. Эдгээрийн дотор Хаалганаас Өргөөд ирсэн анхны машин, Богд гэгээн 8500 доллараар худалдан авсан 20 хүний суудалтай Фиат загварын ачааны машин, Франклин загварын хоёр машин, Форд загварын анхны машинуудын нэг, хорин жилийн өмнө үйлдвэрлэгдсэн хэд хэдэн машин, гурван дугуйтай франц хийцийн машин, хэд хэдэн машины эвдэрхий сэг зэргийг Андриос тоолжээ. Эдгээрээс ажиллагаатай нь ганц техник нь мотоцикл байжээ. Монголын тухай сэтгэгдэлээ Андриос “Монгол орон шиг надад өгсөн тийм мэдрэмжийг би хэзээ ч олохгүй биз ээ...Чингис хааны талын морьтнууд аялж байсан эртний харгуй. Говийн нүүж буй элснээс ирсэн аварга тэмээний хажуу дахь мотортой тэргүүд хосолсон эрс тэс өнгө. Би өөрийнхөө орныг оллоо. Миний төрсөн, мэдэхийг хүсч байгаа, миний хайрладаг орон” хэмээн бичжээ. Монголын ноёд хэр баян байсныг

Р.Андрюс дараах жишээгээр иш татжээ. Цэцэн хан 1919 онд арван мянган адуутай байсан гэтэл 1920 онд хятадууд 2400 адууг нь дайны хэрэгцээнд хураан авсан, орос-буриадууд 1921 онд бүр ч олныг хураан авсан байлаа гэж Андрюс тэмдэглэжээ.

Америкийн Байгалийн түүхийн музейгээс Монголд зохион байгуулсан Төв Азийн гурван удаагийн экспедицийг Р.Андрюс ахлан ажиллажээ. Нью Йоркийн "Wall Street" санхүүгийн бүлгээс санхүүжүүлсэн анхны экспедици 1922 оны 5 дугаар сарын 18-наас 9 дүгээр сарын 15 хүртэл үргэлжилжээ. Тус экспедици Бага богд, Арц богд, Гурван сайхан, Онгийн гол зэрэг газраар хайгуул хийсэн байна. Монголын засгийн газраас аялах зөвшөөрөл өгөх хүртэл экспедицийн үндсэн цуваа одоогийн Чойр орчимд байрлаж байжээ. Түрэн хийдэд мянга гаруй лам оршин суудаг Өргөөд захирагддаг ажил, үйлчилгээний тогтсон маш сайн сүлжээтэй байсныг Андрюс тэмдэглэжээ. Гэтэл Андрюс "Цэцэн ханы хийд Түрэнгийн хийдээс ч том байсан" хэмээсэн байна. Мөн Түрэнд 1921 оны эхээр Монголын жанжин 300-хан цэргийн хамт дөрвөн мянган Хятад цэргийг хүйс тэмтэрсэн тулалдааныг дүрсэлж, 1922 оны хавар экспедицийг буудлах үед тэрхүү тулалдааны ул мөр хэвээр байсныг бичжээ. Тэрхүү жанжинтай Андрюс нэг бус удаа уулзаж дотно нөхөрлөсөн гэж бичсэн бөгөөд түүнийг Хуурамч Дамбий Жаг устгахад оролцсон гэжээ.⁵ Олон тооны машин, тэмээ бүхий цуваа нь үлэмж хөрөнгө зарцуулсаныг харуулж байсан тул экспедицийг зөвхөн шинжлэх ухааны судалгаагаар ирсэн гэхэд үнэмшихгүй, алт, газрын тос хайх зорилготой хэмээн хардаж байжээ. Энэ үед Андрюс Майдарын цамыг үзэж, кино зураг авчээ. Ерөнхий сайд Жалханз хутагт 1922 оны 5 дугаар сарын 17-нд экспедицийг Монголд аялан хайгуул хийхийг зөвшөөрсөн шийдвэр гаргажээ.⁶ Экспедицийн хамт Монголын засгийн газар төлөөлөгчөөр буриад Т.Бадмажапов явсан бөгөөд тэрээр Козловын экспедицтай явж байсан туршлагатай байжээ. Андрюс Бадмажаповтой найз нөхөд болж, олон жил хамтран ажиллаж, тэр бээр экспедицийн ажилд үлэмж тус болсоныг дотноор бичжээ. Анхны экспедицийн хэлмэрчээр Ф.Ларсен явсан байна. Хоёр дахь удаагийн экспедици 1923 оны 6 дугаар сарын 11-нээс 9 дүгээр

⁵ Roy. Chapman Andrews. "The New Conquest of Central Asia". New York, 1932. p.52-53

⁶ Roy Chapman Andrews. "The New Conquest of Central Asia". New York, 1932. p.64.

сар хүртэл Онгийн гол, Шаварт ус зэрэг газраар явсан байна. Энэхүү аялалын үед Ларсеныг байгалийн түүхийн музейн хүндэт гишүүн болгосон тухай Андрюс түүнд мэдэгдэж байжээ. Гурав дахь удаагийн экспедицийн зөвшөөрлийг авахаар Андрюс Ларсений хамт нийслэл Хүрээнд 1924 оны VIII сарын 25-наас IX сарын 20 хүртэл байжээ. Тэрээр гадаад явдлын яамны сайд Цэрэндорж, Ерөнхий сайд нартай уулзаж, экспедицийн зорилго, маршрутыг учирлан тайлбарлаж байсан байна. Монголын засгийн газар шинжлэх ухааны хүрээлэн, тусгай нууц албанаас нэг нэг төлөөлөгч дагуулж явах, бүх олдворын гэрэл зургийн нэг хувийг өгөх, түүгээр нь музей байгуулах нөхцөл тавьж, зөвшөөрлийн төлбөрт гурван мянган доллар төлүүлсэн байна. Андрюс энэ үер Зөвлөлтийн судлаач Козловтой уулзаж, түүний хамт Хүрээний хавьд нэгэн булш шинжлэхэд дагаж бүтэн өдөр явсан байна. Гурав дахь удаагийн экспедици 1925 оны VI сарын 9-нөөс VIII сарын 25 хүртэл долоон машин, монгол 14 ажилтан, орчуулагч, жинчид болон 125 тэмээ хэрэглэн Их богд, Алтайн нуруугаар аялжээ. Андрюсын сүүлийн хоёр экспедици Замын үүдээр дамжилгүй Монголын өмнөд хилээр шууд нэвтрэн орж ажилласан байна. Монголд экспедици явуулах техник зохион байгуулалтын бэрхшээлүүд байсан боловч энэ нь ажлаа эхлэхийн тулд даван туулах улс төрийн бэрхшээлийн дэргэд юу ч биш байлаа гэж Андрюс бичжээ. Экспедици зохион байгуулсан улс төрийн нөхцлийг Андрюс дараах байдлаар дүгнэжээ. Барон Унгернийг үлдэн хөөсөн Зөвлөлт засгийн тусламжтайгаар Монголын улаантнууд улс төрийн нам зохион байгуулж, улмаар Зөвлөлтийн гар хөл болсон. Зөвлөлтийн нөлөө 1922 онд хүчтэй байсан, 1923 оноос энэ нөлөө улам өсч 1925 оны экспедици зохион байгуулахад Монголын засгийн газар Зөвлөлтийн гарт бүрэн орсон байв. Хэдийгээр Монголын ерөнхий сайд, засгийн газар байсан боловч бүхий л хэргийг буриадууд, Зөвлөлтийн сургагч нар хянаж байлаа. Бид Монголд зөвхөн шинжлэх ухааны судалгааны зорилгоор очиж байгаа гэдгийг эрх баригчдад ойлгуулахад туйлын хүнд байсан. Биднийг Хятадтай далдуур сүлбэлдэгчид хэмээн хардаж, шинжлэх ухааны нэрийн дор алт, газрын тос хайсан арилжаа, хонжоо хайсан экспедици хэмээн хардсан, Монголыг эзлэхэд бэлтгэхээр Америкийн засгийн газрын илгээсэн тагнуул гэж хардсан, эдгээр хардлагыг арилгах, паспорт, зөвшөөрөл авахын тулд олон долоо хоногийг зарцуулж байлаа. Жил ирэх тутам

тавигдах нөхцөл хүндэрсээр байв. Ларсен, Бадмажапов, Монгол олон нөхдийн туслалцаагүйгээр энэ ажил бүтэхгүй байв гэж бичжээ.⁷ Андрюс БНМАУ-д 1926 онд экспедицээ үргэлжлүүлэн илгээх бодолтой байсан боловч Хятадын дотоод байдлын улмаас чадаагүй байна. Харин Өвөр Монголын нутгаар 1928 онд аялжээ. Чингэхэд нь тус экспедицийн цуглуулсан үлэг гүрвэлийн яс, өндөг бусад цуглуулгыг Хятадын засгийн газар хураан авсан юм. Үүний улмаас Хятад, Америкийн харилцаа хүйтэрч АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Хятадын ГЯЯ-нд эсэргүүцэл илэрхийлж байж, хураалгасан зарим цуглуулгыг буцаан авч байжээ. Андрюс нийтдээ нэг жил дөрвөн сар гаруй хугацааг Ар Монголд өнгөрүүлжээ. Түүнээс Америкийн олон нийтэд Монголыг танин мэдүүлэхэд гүйцэтгэсэн чухал үүргийн ач холбогдол өнөөдөр ч гэсэн хэвээр байна. Р.Андрюс Төв Азийн экспедицийн Монгол дахь хээрийн ажлын тэмдэглэл, жар орчим гэрэл зураг бүхий “Эртний хүний мөрөөр” номоо 1926 онд хэвлүүлжээ. Номын өмнөх үгэндээ Р.Андрюс экспедицийн багийн өмнөөс Хятад, Монголын засгийн газарт хээрийн ажил хийх зөвшөөрөл олгосонд талархаад ялангуяа Монголд ажиллах зөвшөөрөл авахад үлэмж туслалцаа үзүүлсэн Т.Бадмажаповт (Т.Бадамжав бололтой, шүүх яаманд зөвлөхийн алба хашиж байгаад сүүлд Английн пүүсийн төлөөлөгч болсон гэдэг Р.Б) онцгой талархал илэрхийлжээ. Р.Андрюс “Төв Азийн байгалийн түүх” хэмээх цувралын нэгдүгээр боть болох “Төв Азийг шинээр байлдан дагуулсан нь” хэмээх Монгол, Хятад дахь судалгааны тухай тайланг 1932 онд хэвлүүлжээ. Тайланд Монголд хийсэн гурван удаагийн экспедицийн тэмдэглэл, гэрэл зурагнууд, дүгнэлт тусгагджээ. Эдгээр судалгаа нь палентологи, археологи, хүн судлалын үнэлж баршгүй ач холбогдолтой бүтээл юм.

Андрюс түүний Монголд аялах хугацаанд улс төрийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг бичихдээ “Өргөөд 1919 онд ирэхэд чөлөөт хот байлаа. Өргөөгийн гудамжинд Төв Азийн бүхий л үндэстэн ястныг харж болох байв, өнгө алаглуулсан, сонин чамин янз янзын хувцастай хүмүүс Өргөөгийн гудамжаар явна. 1922 оноос хойш байдал эрс өөрчлөгдөж, гудамжинд цэрэг нэртэй Монголчууд бөөгнөрч, гудамжны үзүүрт пулемет зоолттой, буриадууд газар сайгүй харагдах болсон, зөвлөлт Монголыг буриад нутаг болгох бодлоготой байв. Өргөөгөөс орж, гарах нь

⁷ Roy Chapman Andrews. “The New Conquest of Central Asia”. New York ,1932 p.8-9

хатуу хяналттай хардлага, сэжиглэл газар авсан. Дөрвөн аймгийн хан эрх мэдлээ алдсанаар 1925 онд Монгол Зөвлөлтийн мэдэлд бүрэн орсон. Монголчуудын ялгардаг шинж чанар нь тусгаар тогтнол, эрх чөлөөг дээдлэх явдал. Өргөөд тогтоосон элдэв хязгаарлалт нь Монголчуудын энэхүү эрхэм чанарыг хулгайлж, цэвэр цусны Монголчууд хөдөө нутагт гарч, хотыг буриадаар дүүргэхэд хүргэжээ” гэсэн байна.⁸

⁸ Roy Chapman Andrews. "The New Conquest of Central Asia". New York, 1932.p.57